



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 01 дугаар
сарын 11-ны өдөр

Дугаар ХЭГ/78

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах, түүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд олгосон зээлийн зарцуулалт, эргэн төлөлт, бий болгосон ажлын байр, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ, “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” байгуулах дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажлын төлөвлөлт, малын удмын санг хамгаалах, эрүүлжүүлэх болон ашиг шим сайтай малын тоог нэмэгдүүлэх, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа арьс, шир боловсруулах үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх зэрэг асуудлаар Танаас Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн ямаар бэлтгүүлэн холбогдох материалын хамт үүгээр уламжлан хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

000063



**МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2018.01.09 № 01/99
танай ~~2017.02.08~~ -ны № 17 -т

Асуулгын хариу

Танаас 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 17 дугаартай албан бичгээр ирүүлсэн асуулгын хариуг хүргүүлж байна.

1. Арьс ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд олгосон хөнгөлөлттэй зээлийн зарцуулалт, эргэн төлөлт, түүний үр дүнд 2015 оны 04 дүгээр сар, 2016 оны 11 дүгээр сард хоёр удаа мониторинг хийсэн тайланг нэгдүгээр хавсралтаар илгээлээ.
2. Арьс ширний үйлдвэрийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах талаар УИХ-ын тогтоолоор өгөгдсөн үүргийн хэрэгжилтийн талаар Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд танилцуулга мэдээлэл хийж, Засгийн газрын хуралдааны 50 дугаар тэмдэглэл гарсан.

Уг тэмдэглэлийн дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 173 дугаар захирамжаар Эмээлт паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа холбоог хангах, паркийн бүтээн байгуулалтын эрх зүй болон бусад ажлыг эрчимжүүлэх, паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг судалж, шийдвэрлэх арга замыг танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.

Тус ажлын хэсгийн даргаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, ажлын хэсгийн гишүүдэд салбарын яамдын төлөөллүүд багтсан. Ажлын хэсгийн удирдамжийн дагуу төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа ба 2018 оны 1 дүгээр улиралд багтаан УИХ-ын 2012 оны "Малчид үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 74 дүгээр тогтоолын 2.5 дахь заалтын хэрэгжилтийн хугацааг сунгах, өөрчлөх тогтоолын төсөл боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Холбогдох материалуудыг хоёрдугаар хавсралтаар хүргүүлээ.

3. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 356 дугаар тогтоолын 1 дүгээр заалтад “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан арьс, ширний үйлдвэрүүдийн цогцолборыг Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг “Шар хөцийн хоолой” гэдэг газарт төвлөрүүлэн байршуулах тухай нийслэлийн удирдлагын саналыг дэмжсүгэй” гэж, уг тогтоолын 3 дугаар заалтад ““Арьс, ширний үйлдвэрлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 249 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.” гэж тус тус заасны дагуу Нийслэлийн ЗДТГ-ын дэргэд “Эмээлт хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк” Орон нутгийн өмчит төсөвт аж ахуйн газрыг 2014 онд байгуулсан.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2011 онд “Идеал групп”-ийн гүйцэтгэсэн “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк”-ийн ТЭЗҮ-д 2015 онд “Ар энд эф капитал” ХХК-аар нэмэлт, тодруулга хийлгэсэн байна. Үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр Нийслэлийн концессийн жагсаалтад оруулж, концесс зарласан боловч шаардлагад нийцсэн санал ирээгүй тухай Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас мэдээллэдэг.

Уг тогтоолын 2 дугаар заалтад “Арьс, ширний үйлдвэрүүдийн цогцолборын дэд бүтцийн бүтээн байгуулалтын болон хаягдал усыг цэвэршүүлэх, ариутгах, дахин ашиглах орчин үеийн дэвшилтэт технологитой цэвэрлэх байгууламжийг байгуулах ажлыг 2014 оны 11 дүгээр сараас эхлэн Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамтай хамтран шуурхай зохион байгуулахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Ш.Түвдэндорж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл нарт тус тус үүрэг болгосугай.” гэж заасан.

Энэ асуудлыг Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанд танилцуулсан боловч, Завхан аймагт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Шинэ Азиа групп” гэх ХХК-д 4 жилийн хугацаатай олгож, 352 дугаар тогтоолоор баталсан.

2014 оны 11 дүгээр сард Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орж, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам татан буугдаж, үйлдвэрлэл технологийн паркийн асуудал шинээр байгуулагдсан Аж үйлдвэрийн яамны чиг үүрэгт хамаарах болсон. Аж үйлдвэрийн яаманд Чөлөөт бүс, Үйлдвэрлэл, технологийн паркийн хэлтэс байгуулагдсан боловч “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк”-ийн чиглэлээр тодорхой ажил хийгээгүй. Аж үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын 2015 оны жилийн эцсийн тайланг Аж үйлдвэрийн сайдад танилцуулах үед арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэх гэхээс үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн техник, технологийг шинэчлэх нь оновчтой шийдэл гэж үзсэн.

Энэ шийдвэрийн дагуу "Арьс ширний үйлдвэрүүдийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх" төслийн саналыг Засгийн газрын хуралдаанаар 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр хэлэлцүүлж, 459 дүгээр тогтоолоор батлуулсан. Энэхүү тогтоолын дагуу "Арьс ширний үйлдвэрүүдийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх" төслийн үндэслэл, танилцуулгыг Бүгд Найрамдах Солонгос Улсын ЭКСИМ банкны Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн фондын холбогдох маягтын дагуу бэлтгэж, Монгол улсын Сангийн яамны Зээл тусламжийн газраар дамжуулан хүргүүлсэн. Түүнчлэн Монгол улсын Засгийн газрын шинэ бүтэцтэй холбогдуулан, Сангийн яамнаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас дээрх хүсэлтийг 2016 оны 09 дүгээр сарын 27-ны 01/533 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Энэ дашрамд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас дэмжсэн саналыг албан бичгээр авсан болно.

Тухайн үед Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь "Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдэж, үйлдвэрүүд шилжин очих хүртэл хугацаанд арьс ширний үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжийг хэвийн жигд ажиллуулах шаардлагатай гэсэн байр сууриа илэрхийлсэн.

Гэтэл Нийслэлийн Засаг даргаас Сангийн яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд утгын зөрүүтэй санал хүргүүлж асуудлыг зогсонги байдалд хүргэсэн.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2018 онд Цэвэрлэх байгууламж, технологийн болон ундны усан хангамж болон парк доторх инженерийн шугам сүлжээ, авто замын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийхээр 107,0 тэрбум төгрөг, 2019 онд Дулааны станц, үндсэн цахилгаан хангамж, үерийн усны барилга байгууламж, арьс ширний лабораторийн хөрөнгө оруулалт хийхээр 72,0 тэрбум төгрөг, 2020 онд Шинжлэх ухаан технологи, инновацийн төв, паркийн төмөр зам, логистик төв, агуулахуудын хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлж, бүтээн байгуулалт хийхээр 93,0 тэрбум төгрөг тус тус төсөвлөсөн.

Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад хөрөнгө оруулалт олох зорилгоор Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны дэргэдэх "Төсөл бэлтгэх тусгай сан"-ийн шугамаар дэмжих төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр 2016 оны 10 дугаар сард санал хүргүүлсэн.

Мөн Монгол Улс, Кувейт улстай хийх хэлэлцээрт Арьс ширний үйлдвэрийн кластерийн дэд бүтцийг байгуулах, Арьс ширний үйлдвэрийн мэргэжилтэй ажилчин бэлтгэх Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах төслийн хөрөнгө оруулалтыг Кувейтийн сангийн зээлээр хэрэгжүүлэх саналыг Гадаад харилцааны яамаар уламжлуулан Монгол Кувейтийн Засгийн газрын хоорондын Комиссын хуралдаанд хэлэлцүүлсэн.

БНСУ-ын ЭКСИМ банкны Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн фондын /EDSFund/ буцалтгүй тусламжаар үйлдвэрлэл, технологийн паркийн Цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ-г гүйцэтгүүлэхээр албан бичгээр Сангийн ямаар уламжлуулан хүсэлт гаргасан. Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх төслийг Туркийн ЭКСИМ банкны зээлийн хүрээнд хэрэгжүүлэх боломжийн талаар Туркийн хөрөнгө оруулагчдад санал тавьсан. Дээрх талуудаас албан ёсны хариу ирүүлээгүй байна. "Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн ажлыг 2018 оноос эрчимжүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд санаачилга гаргаж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 173 дугаар захирамжаар Ажлын хэсэг байгуулсан бөгөөд Эмээлт паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг судалж, шийдвэрлэх арга замыг танилцуулахаар ажиллаж байна. Одоогийн байдлаар Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу салбар яамдууд болон Сангийн яам чиглэлийнхээ хүрээнд боломжит санхүүжилтийн эх үүсвэрүүдийг судалж байна. 2018 оны 01 дүгээр сард багтаан Ажлын хэсгээс боломжит саналуудыг Засгийн газрын хуралд танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна. Энэ асуудалтай холбогдолтой материалуудыг гуравдугаар хавсралтаар хүргүүлээ.

4. Засгийн газар нь малын удмын санг хамгаалах, эрүүлжүүлэх, үйлдвэр угсааг сайжруулах, ашиг шим сайтай малын тоог нэмэгдүүлэхтэй холбоотой ямар арга хэмжээ хэрэгжүүлж байгаа, малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлж нэмэгдсэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар хэрхэн бодлого боловсруулан ажиллаж байгаа талаар мэдээллийг дөрөвдүгээр хавсралтаар хүргүүлээ.
5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх болон Паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгжүүдийн эрх зүйн байдлын талаар болоод гарах эрсдлийг урьдчилан тооцож, төлөвлөх ажлыг Ажлын хэсэг судалж байна. Үйлдвэрүүдийн хэтийн төлөвлөлт, хөгжлийн чиглэлийн талаар Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийцүүлэн "Эмээлт хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн хөгжлийн хөтөлбөрт тусган ажиллаж байна.

Хавсралт & хуудастай.



Б.БАТЗОРИГ